



ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ПРОТОКОЛ

ХУРАЛДСАН ГАЗАР: Хан-Уул дүүрэг, 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоот

ХУРАЛ ҮРГЭЛЖИЛСЭН ХУГАЦАА: 10:00-11:00

ХУРАЛД ОРОЛЦСОН:

YEN MONTGOMER /хувьцаа эзэмшигч 89.6%/

Ц. ОЮУНТУЯА /5.0% хувьцаа эзэмшигч /

HE SHANJUN /5.0% хувьцаа эзэмшигч /

ХУРАЛ УДИРДСАН:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дарга: HE JINGWEN

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Т.БАЯРМАА

ХУРАЛД БАЙЛЦСАН:

1. He Jingwen /Гүйцэтгэх захирал /
2. Пүрвээ Очирхуяг /биечлэн/ /ТУЗ-н гишүүн/
3. Shih Pei Chin / эчнээ¹ / /ТУЗ-н хараат бус гишүүн/
4. Ku Cheng-Chuan / эчнээ¹ / /ТУЗ-н хараат бус гишүүн/
5. Tsai Chin-Kun / эчнээ¹ / /ТУЗ-н хараат бус гишүүн/
6. Lin Yu-Fei / эчнээ¹ / /ТУЗ-н гишүүн/

ТООЛЛОГЫН КОМИСС:

Б.БАТЦЭЦЭГ /дарга/

Э.АНХБАТ /гишүүн/



Эчнээ¹ - We Chat conference call

2019 ОНЫ 11 САРЫН 18

“ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ПРОТОКОЛ

2019 оны 11 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 11 дугаар сарын 18 -нд 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоотод 10:00 цагт эхлэв.

Тооллогын комиссын дарга Б. Батцэцэг хурлын ирцийг бүртгэж, нийт 3 хувьцаа эзэмшигч ирсэн нь нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.6 хувийн ирцийг бүрдүүлж байгааг мэдэгдлээ.

Хурлын дарга He Jingwen хурлыг нээж хүрэлцэн ирсэн хуралд оролцогчдод мэнд дэвшүүлэн хурлын дэгийг танилцуулаж, уламжлал ёсоор орчуулга хийв.

2019 оны 9 дүгээр сарын 30 ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталсаны дагуу нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтийг болон нэр дэвшигчдийг ТУЗ-н дарга Баярмаа танилцууллаа. Хувьцаа эзэмшигчид нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт, шийдвэртэй санал нэг байгаагаа илэрхийллээ.

Компанийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн тухай СЗХ-ны даргын 538 тоот тушаал 2019 оны 11 дүгээр сарын 14 ний өдөр гарсан. Холбогдох шат дарааллийн дагуу Компанийн хуучин нэрийг /Баялаг сүмбэр/ Өнөөдөр сонинд 11 сарын 15 ны өдөр зарлуулж хүчингүйд тооцон шинээр Глобал лайф технологи болгож буйг нийтэд зарласан тухай ТУЗ-н нарийн бичиг Баярмаа танилцуулж энэ хурлаас гарах тогтоол болон холбогдох баримт бичгүүд нь шинэ нэрээр хаяглагдахыг тайлбарлалаа.

Тооллогын комисс саналын хуудсыг шалгаж, тоолж, тогтоолоо танилцуулав.

Ийнхүү хэлэлцсэн асуудлын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төслийг Гүйцэтгэх захирал He Jingwen нийт гишүүдэд орчуулж өгч танилцуулав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА:

/HE JINGWEN/

